

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан журмын 4 дүгээр хавсралт

**УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ, ГАЗРЫН ТОС УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОС, ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ХУУДАС**

Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: "Сонор трейд" ХХК  
 Төслийн байршил: Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Цагаанчулуутын уурхай  
 Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-001817  
 Огноо: 2024.02.23

#	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо							Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
			Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6	Гишүүн 7		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	30	27		26	27	29		30	22,64%	
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/		—		—	—	—		—	—	
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	40	40		38	40	40		40	99%	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт		—		—	—	—		—	—	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт		—		—	—	—		—	—	

6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	10	8	9	10	10	89,6%
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	5	5	4	5	5	96%
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	5	5	4	4	5	92%
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	4	5	4	5	5	92%
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	4	5	3	5	5	88%
Нийт оноо		100	96	92	90	98	100	91,31%

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээс нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунджийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунджийн нийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн нийт оноо нь 90-аас доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд дүйцүүлэн хамгаалах ажил төлөвлөгдөөгүй бол нөхөн сэргээх арга хэмжээ рүү, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно.

АКТ ГАРГАСАН:

Ажлын хэсгийн ахлагч:

.....  
 (Гарын үсэг)  
 Нарийн бичгийн дарга: .....  
 (Гарын үсэг)

З.Түвшинтөгс

(Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Н.Эрдэнэцогт

(Байгаль орчин, аялал жуулчлалын Газар, Газрын хэвлий, уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг хавсран аүйцэтгэгч)

## Гарчиг

<b>1. Төслийн товч танилцуулга</b> .....	3
1.1 Төслийн уулын ажлын төлөвлөгөө товч танилцуулга.....	4
1.2 Төслийн зорилго.....	5
1.3 Төсөл хэрэгжиж буй газар засаг захиргаа.....	5
1.4 Төсөл хэрэгжүүлэгч.....	5
1.5 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг.....	6
1.6 Төсөл хэрэгжиж буй байршил.....	8
<b>2 Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт</b> .....	9
<b>3 Нөхөн сэргээлийн төлөвлөгөөний биелэлт</b> .....	15
<b>4 Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт</b> .....	22
<b>5 Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний биелэлт</b> .....	24
<b>6 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт</b> .....	24
<b>7 Химийн бодис эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт</b> .....	24
<b>8 Осол эрсдлийн бууруулах менежментийн төлөвлөгөөний биелэлт</b> .....	24
<b>9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт</b> .....	28
<b>10 Орчины хяналт-шинжилгээний хөтөлбөр</b> .....	31
<b>11 Удирдлага зохион байгуулалт менежментийн төлөвлөгөөний биелэлт</b> .....	32
<b>12 БОМТ нийт зардал</b> .....	35

## Оршил

“Цагаанчулуутын” аман дахь талбайд 1913 оноос 1918 он хүртэл хувь нийлүүлсэн Монголор нийгэмлэг, 1943-1956 онуудад Монголын уул уурхайн алба ашиглалт явуулж байсан. Энэ ордын зураглал эрэл хайгуулын ажлыг 1950-1970 онуудад хийж байсан ба 1982 онд Монгол-Германы хамтарсан геологийн экспедиц нөөцийн судалгаа хийж, тайлан гаргасан байна. 2000-2012 онуудад далд аргаар ашиглан батлагдсан нөөцийг бүрэн олборлож дуусгасан. 2012-2013 онуудад нэмэлт хайгуулын ажил хийж хайгуулын ажлын үр дүнг 2019 онд 89 мян.тн хүдэр 105.21 кг алны нөөцийг ЭБМЗ-өөр батлуулан бүртгүүлсэн.

Нөөцийг байгаль орчинд хор нөлөөлөл багатайгаар алтны үндсэн ордыг бүрэн ашиглах багана болон гарш хэсгийн цулд үлдсэн нөөцийг ил аргаар олборлон авах зорилгоор 2018 онд Балчулуу ХХК-иар ТЭЗҮ-г хийлгэн батлуулсан.

2019-2020 онд далд аргаар ашиглах явцад хаягдсан ашиглалтын хаягдал буюу хамгаалалтын багана, карьерийн цулд үлдсэн хаягдлыг ил аргаар олборлон дуусгасан.

2019 онд батлагдсан нөөцөд үндэслэн ордыг далд аргаар ашиглах ТЭЗҮ-г “Грийн Вишн” ХХК гүйцэтгүүлэн батлуулсан бөгөөд 2021-2023 онд далд аргаар олборлолтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 19-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу боловсруулав.

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.

“Цагаанчулуутын” 1817А тоот 25 гектар хэмжээтэй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь (Зураг №1) Улаанбаатар хотоос хойш 135км, төмөр замын Баруун хараа өртөөнөөс (Баянгол сум) зүүн урагш 28км зайд оршдог. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицол (Зураг №2)

1. 106° 12' 9.2"	48° 42' 25.87"
2. 106° 12' 9.2"	48° 42' 1.88"
3. 106° 11' 39.2"	48° 42' 1.88"
4. 106° 11' 39.2"	48° 41' 44.86"

Ордын талбай нь Хойд Хэнтийн төвийн өргөрөгийн уулархаг мужид оршдог. Рельефийн хувьд хөндий, хоолойгоор тусгаарлагдсан 900-1500м өндөрлөг газар байрлана.

### **Цаг уур**

Цаг уурын хувьд эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай, хуурайдуу сэрүүвтэр болон чийглэгдүү сэрүүн мужийн нэн хүйтэн дэд муж бүхий зааг нутагт оршино. Жилийн дундаж агаарын температур -1.0°C, нийлбэр хур тунадас 308мм, үүний 90% нь 5-9 сард унадаг. Жилд бороотой өдрийн тоо 50-аас дээш, цас орох өдрийн тоо 20-30 хоног тус тус байна. Хамгийн хүйтэн нь 1-р сард -40ч-46°C, хамгийн халуун нь 7, 8-р саруудад +36ч38°C хүрдэг. Салхины жилийн дундаж хурд 2.4м/сек, хамгийн их хурд хавар 14-24м/сек. Уурхайн орчинд 5-6м/сек хурдтай салхилдаг.

### **Дэд бүтэц**

Дэд бүтцийн хувьд эрчимтэй хөгжиж байгаа төвийн бүст хамаарна. Тус орд нь Улаанбаатар-Сүхбаатарын хатуу хучилттай замаас зүүн зүгт 3км зайд байрладаг. Уурхайгаас зүүн хойш 8км зайд “Бороо гоулд” компаний алтны үйлдвэртэй. Үндсэндээ 25-90км радиус дотор сумын төвүүд, үйлдвэрийн төвлөрсөн газруудтай, асфалтан болон төмөр замтай. Бүх төрлийн үүрэн телефоны холбоотой, интернет сүлжээнд бүрэн холбогдсон, байнгын ажиллагаатай зочид буудал, дэлгүүр ба ахуйн үйлчилгээний цэг, салбарууд бий. Ордын ойр орчим газар тариалан, мал аж ахуй маш сайн хөгжсөн.

## **1.1 УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

“Сонортрейд” ХХК нь Цагаанчулуутын алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэхээр 2020 онд “Грийн Вишн” ХХК-иар жилийн 24мян.тн хүдэр олборлох, боловсруулах хүчин чадалтай байх үеийн ТЭЗҮ-г боловсруулсан. Энэ онд **В-4, В-5, С-12** блокуудад олборлолт явуулсан.

Энэ онд нийт 11270 тн хүдэр, олборлож 8кг химийн цэвэр алт боловсруулан баяжуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 12407 тн хүдэр боловсруулав.

Уулын ажил 3-р сарын 28 нд, үйлдвэрийн үйл ажиллагаа 4 –р сарын 15-аас эхлэн 2 ээлжээр 20 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав.

Төслийн нийт хамрах хүрээ нь “Сонортрейд” ХХК-ний эзэмшлийн 25га талбайтай Цагаанчулуутын алтны үндсэн ордын батлагдсан хүдрийн нөөцийг олборлох боловсруулах ажлуудаар хязгаарлагдана.

### **УУЛЫН АЖЛЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

“Цагаанчулуутын” алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах Техник эдийн засгийн үндэслэлд тусгасан техник, тоног төхөөрөмжүүдийг үйл ажиллагаандаа ашигласан. Үүнд : Комбайн -1ш, 1тн даацтай өөрөө буулгагч 4ш, LIUGONG маркын дугуйт ачигч-1ш, УТ-28маркын өрөм-2ш, хийн компрейссор-2ш, түлш түгээлтийн запрушка-1ш, HYUNDAI 2800 экскаватор 1ш, HOWO өөрөө буулгагч 1ш тус тус техникийн хүчин чадалтай ажиллаж байна.



Зураг 1 Hyundai 2800 экскаватор



Зураг 2 Хово өөрөө буулгагч



Зураг 3 LUGONG маркын дугуйт ачигч



Зураг 4 Запрушка



Зураг 5 бага оврын өөрөө буулгагч

## 1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Сонортрейд” ХХК нь ордыг бүрэн дүүрэн ашиглах зорилгоор 2019 онд батлагдсан нөөцийг далд аргаар олборлож ордыг хаягдалгүй байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглан эдийн засгын эргэлтэд оруулахад оршино.

## 1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЗАСАГ, ЗАХИРГАА.

“Сонортрейд” ХХК-ний Цагаанчулуутын алтны үндсэн орд нь Засаг захиргааны харьяалалаар Сэлэнгэ аймгийн Баянгол сумын гонир багын нутагт багтдаг.

## 1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ.

“Сонортрейд” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: № 9011196033, регистр 2590565


**1.5 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ.**

**Хүснэгт 1**

Аж ахуй нэгжийн нэр	“СОНОР ТРЕЙД” ХХК	
Аж ахуй нэгжийн хаяг	Аймаг хот	Улаанбаатар
	Сум, Дүүрэг	Сүхбаатар
	Баг, Хороо	8-р хороо
	Гудамж, Байр	Залуучуудын өргөн чөлөө
	Шуудангийн хайрцаг	ШХ-14
	Утас	311029
	Факс	976-11-323424
	Гар утас	99214188
Захиралын хаяг	Электрон шуудан	sonortrade@yahoo.com
	Овог/Нэр	Б. Энхболд
	Утас	311029
	Факс	976-11-323424
	Гар утас	99115698
	Электрон шуудан	sonortrade@yahoo.com

**1.6 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН БАЙРШИЛ**

Орд нь Улаанбаатар хотоос хойд зүгт 135км, Баруунхараа төмөр замын өртөөнөөс /Баянгол сум / зүүн урагш 28 км Улаанбаатар- Сүхбаатарын хатуу хучилттай замаас зүүн зүгт 3км зайд оршино. Орд нь Бороогийн нууранд орших алтны үндсэн бүлэг ордын зүүн хэсэгт байрлана.




- Цагаанчулуутын алтны үндсэн орд



“Цагаанчулуутын “ алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийн талбайн байршил

Зураг № 8



## Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт.№-2

Болзошгүй сөрөг нөлөөлөл		Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хугацаа	Баримтлах хууль, стандарт, аргачлал
<b>Агаарын чанарт</b>								
№								
1	Тоосжилт	Олборлож буй хүдрийн чийгшилт 10% байгаа нь тоосжилт үүсэхгүй байх нөхцөл бүрдүүлж байна	м3	0	0	0	2023.4.2023.10	-“Агаарын тухай” хууль, 2012 он -MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага; MNS (ISO) 4226:2000 шаардлага
2	Төсөл хэрэгжиж буй орчин түүний эргэн тойрон нутаг дэвсгэрт тоосжилт үүсэх	Мониторингийг цэгийг үйлдвэрийн болон кемпын бүсэд тогтоон KHAN LAB лабораторид шинжилгээ хийлгэхэд агаарын чанарт өөрчлөлт гараагүй	-	1	50	50	8сард	
3	Техникээс гарах хорт утааг багасгах	Техникт өдөр тутамын үзлэг шалгалтыг ээлж солилцох бүр 2-р оператор хуудасын үзлэг хийж тэмдэглэл хөглөсөн АТӨЯМТХэрэгсэлийн татвар төлөв.	жил	1	-	270	2023	
4	Тос масло, дизелийн түлш ууршилт	Тухайн явсан мот/цагаас хамааруулан техникт засвар үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол хийсэн	сар	3	350	1050	2023.3-2023.12	
<b>Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт нийт зардал</b>						<b>1370 мян\төг</b>		
<b>Усны чанарт</b>								
Цэвэр усны химийн шинжилгээ	Ундны ус, гадаргын ус		ш	1	1	49	2023.5,8 саруудад	Усны тухай” хууль, 2012 он;

Гадаргийн ус бохирдох	Техникийн засвараас гарч буй ажилласан масло гидрийг зориулалтын саванд тосч тухайн оператор аюултай хог хаягдлын цэгт тушаах ажлыг ажилтан бүрт хэвшүүлж аюултай хог хаягдлын цэгт төвлрүүлэн бүртгэл хөтлөж тэмдэглэв.	м2	120	-	-	2023	-“Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хууль, 2012 он; -MNS 0900:2010 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” -MNS 4943:2011
Усны нөөц хомсдох	Хүдэр боловсруулах шат дамжлагын явцаас гарсан хаягдал шламныг 3950м3 багтаамжтай “Тунаах нуурт” хуримтлуулан 450м3 багтаамжтай эргэлтийн нуураас QJ-5,5/100/10T-22 насосоор 50 диаметртэй 150 м урттай хоолойгоор дамжуулан эргэлтийн ус болгон хүдэр боловсруулалт болон зам талбайн тоосжилт арилгахад ашигласан мөн далд уурхайн шүүрүүлийн усыг эргэлтийн усны нуурт сэлбэлтийн ус болгон ашиглав. Баяжуулах үйлдвэрт алт боловсруулахад зарцуулсан технологийн усны 65%-ыг эргэлтийн нуураар тэжээсэн бөгөөд үлдсэн 35%- нь хүдрийн чийгшил-15%, элсний чийгшил-13%, ууршилт-7% тус тус эзэлдэг. Алдагдсан ус болох 30%-35%-ыг нэмэлт ус буюу гүний цэвэр усны худагаас ашиглав.	-	-	-		2023	
<b>Усны чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийн нийт зардал</b>						<b>49 мян\төг</b>	

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Хугацаа	Баримтлах хууль, стандарт, аргачлал
<b>Хөрсний чанарт , Ургамалан бүрхэвч, газрын хэвлийд</b>							
Олон салаа зам гарах	Төсөлд хэрэгжиж буй талбайд тээвэрлэлтийн траншейнаас өөр бусад эрүүл газраар техник хэрэгслээр зорчихгүй байх Байгаль орчноо хамгаалах талаар ерөнхий мэдлэг олгох сургалт орсон	удаа	1	-	0	2023	-“Агаарын тухай” хууль, 2012 он -MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага; --MNS (ISO) 4226:2000 шаардлага
Ахуйн хэрэглээний бохир ус	Ажилтаны усанд орох , гар нүүр угаах , бие засах, ажилчдын ажлын хувцас угаах зэрэгт ашиглагдаж гарсан бохир усыг хөрсөнд нэвчүүлэх аргыг ашиглан зайлуулдаг бөгөөд хөрсний бохирдолыг бууруулах зорилгоор 10тн багтаамжтай чайн суурлуулж лагыг тунгаав.	удаа	1	-	0	2023	
Асгаралтын улмаас ургамалын насжилт богинсох	Түлш түгээх ажлыг зориулалтын техникээр түгээлтийн ажлыг хуваарын дагуу хийдэг.	удаа	-	-	0	тухай бүрт	
<b>Хөрс болон ургамалын бүрхэвч, газрын хэвлий чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийн тайлан нийт дүн</b>					<b>0 мян\төг</b>		
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийн нийт зардал /мян.төг/</b>					<b>1419 мян\төг</b>		

**Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлтийн ажлын үйл явц**

**Зураг№-9** Үйлдвэрээс гарсан хаягдал элс нь чийгшлийн хувьд 15% хүртэл чийгшилтэй байгаа боловч өөрийн чийгийг алдаж хуурайшин цагаан тоос босох нөхцлийг бүрдүүлдэг учир бороо хур бага үед элсний овоолгийн гадаргууг хусах эсвэл 1-2м зузаан чийгтэй элсээр хучих ажлыг хийж тоосжилтоос урьдчилан сэргийлэв.



**Зураг№-10** Олборлосон хүдрийг шигшиж 2 фракц болгон ангилах ба 30мм-ээс бага ширхэглэлтэй хүдрийг үйлдвэрийн порцесс руу шууд нийлүүлж +30мм хүдрийг бутлах процесст оруулахаар ангилан овоолго үүсгэнэ. Энэ нь хүдрийн талбайд тоосжилт үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой.



**Зураг№-11** Бутлах хүдрийн талбай



**Зураг№- 12** Анхдагч хүдрийн талбай



**Зураг №-13** Бутлагдсан хүдэр



**Зураг №-14** Нөөцийн талбай



**Зураг №- 15** Ажилчдын хувцас, усанд орох, гар нүүр угаах зэрэг ахуйн хэрэглээнээс гарч буй саарал усыг хөрсөөр нэвчүүлэн цэвэрлэх аргыг ашигладаг. Бөгөөд 10тн багтаамжтай чайн суурилуулан лагыг тунгаан орчины хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажилласан.



**Зураг №-16** Түлш түгээх зориулалтын машин хэрэглэсэнээр түлш асгарах уурших зэрэг хөрсөнд шууд үзүүлэх сөрөг нөлөөлөл багассан.



**Зураг №-17** Далд уурхайгаас олборлосон хүдрийг 30тн –ын даацтай өөрөө буулгагчаар 0.4км технологийн замаар зөөвөрлөн анхдагч хүдэр хүлээн авах талбайд хүргэнэ. Энэхүү тээвэрлэлт нь хоногт 2-4-н удаа хийгдэх тул тоосжилт эрс багассан.



**Зураг №- 18** 50мм –ийн хөндлөн огтлол бүхий цагаан PVC хоолойгоор газрын гүний усыг соруулан шахаж эргэлийн нуурт шахсанаар усыг эргэлтэд оруулж зөв зохистой хэрэглээг би болгох сайн талтай.



**Зураг №-19** Уурхайгаас олборлосон хүдрийг 2тн даацтай өөрөө буулгагчаар далд уурхайн ам буюу ил уурхайн ёроолд байх хүдэр буулгах талбайд нөөцөлнө.

Уг талбайд 80-120тн хүдэр нөөцлөгдмөгц уурхайн хүдэр хүлээн авах талбай руу ачуулна.



**Зураг №-20** Ил уурхайг тойруулан үерийн далан татаж гар болзошгүй үер усны болон хүн-мал, амьтан унаж бэртэхээс сэргийлэв.





**Зураг №-21** Уурхайн бүсэд байршуулсан тэмдэг тэмдэглэгээ

**3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт**

Сонор трейд ХХК-ний Цагаанчулуутын далд уурхай нь 2018-2020 онд үүссэн ил уурхайн ёроол хэсэгээс үндсэн траншей нэвтрэн орж 2019 онд ЭБМЗ-өөр батлагдсан нөөцийг нээсэн тул ордын нөөц дуусч хаалтын төлөвлөгөөнд тусгагдан хийгдэх тул энэ онд нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй

Төслийн хүрээнд уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн нийт талбай 13.178-аас 1.4га талбайд техникийн нөхөн сэргээлтийг 2020 онд хийж 2021онд биологийн нөхөн сэргээлтийг 1.2га тайлбайд хийснээр нөлөөлөлд өртсөн талбайн нийт хэмжээ 11.978га

**Хүснэгт -3****Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн талбай**

№	Үйл ажиллагааны төрөл	Талбайн хэмжээ /га/
<b>Ил уурхайн нөлөөлөлд өртсөн талбай</b>		
1	2019 онд олборлолтод өртсөн талбай	2.6
2	2020 онд олборлолтод өртсөн талбай	1.4
3	Гадаад овоолго	4.9
4	Технологийн зам	1.6
5	Засвар, паркын талбай	0.2
6	Хүдэр овоолгийн талбай	0.72
7	Хаягдалын сангийн талбай	1.5
8	Барилга байгууламжын талбай	0.168
9	Тэсэлгээний агуулахын талбай	0.09
	Бүгд	13.178
<b>Далд уурхайн нөлөөлөлд өртсөн талбай</b>		
1	2021 онд олборлолтод өртсөн талбай	0.24
2	2022 онд олборлолтод өртсөн талбай	0
3	2023 онд олборлолтод өртсөн талбай	0.26
4	Гадаад овоолго	0
5	Технологийн зам	0
6	Засвар, паркын талбай	0
7	Хүдэр овоолгийн талбай	0
8	Хаягдалын сангийн талбай	0
9	Барилга байгууламжын талбай	0
10	Тэсэлгээний агуулахын талбай	0
	Бүгд	0.5
<b>Ордын хэмжээнд нийт</b>		13.578

### 3.1 “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

Энэхүү хөдөлгөөний хүрээнд тарих модны тоог уурхай болон үйлдвэр байршиж буй байгалийн бүсчлэлийг харгалзан MNS5918:2008, байгаль орчин, эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлагын дагуу 400ширхэг модыг уурхайн хашаанд тарив.

Зарцуулах зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 07-р сарын 9-ны өдрийн А/172, 116 –рт “ойжуулалт ойн аж ахуйн арга хэмжээний зардлын жишиг нормативыг шинээр болон шинчилэн батлах тухай” тушаалд зааснаар тооцов.

Хүснэгт №5

№	Нэр/төрөл	Тоо/ширхэг	Нэгж бүрийн үнэ. мян.төг	Нийт үнэ мян.төг
1	Улиас	35 ш	-	0
2	Чацаргана	110ш	3	3300
2	Үхэрийн нүд	59 ш	2.5	147.5
3	Нийт	189		
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний арга хэмжээний нийт зардал 3447.5 мян.төг				



Зураг№-22 3.5м урттай улиас шилжүүлэн суулгав /6-23/



Зураг№-23 Чацаграганы мод тарив /5-23/



Зураг №- 24 10-р сарын 25-ны байдлаар



Зураг №-25 Уурхайн ёроол, далд уурхайн ам



**Зураг №-26** Дотоод овоолгийн биологийн нөхөн сэргээлт одоогийн байдал /10-25



**Зураг №-27** Уурхайн одоогийн байдал /10-25/



**Зураг №-28** Гадаад овоолгийн одоогийн байдал /10-25/

#### 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5-р хэсгийн 5.1.8 дахь заалт Уул уурхайн үйл ажиллагааны улимаас эвдэрч, олон жил орхигдсон 8мян\га талбайг нөхөн сэргээлт хийх зорилт болон дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хүний үйл ажиллагаагаар эвдэрч орхигдсон Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас 70км зайд байршилтай “Их өлөнт” нэртэй газарт 3га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэв.

#### Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай солбилцол булангын цэгүүд

Хүснэгт №4

Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	107°	22'	38.43"	49°	24'	45.69"
2	107°	22'	29.82"	49°	24'	37.25"
3	107°	22'	25.55"	49°	24'	38.75"
4	107°	22'	34.98"	49°	24'	47.57"

Дүйцүүлэн хамгаалах нийт зардалд 21.4 сая төгрөг



Зураг.№-29 техникийн нөхөн сэргээлтийн өмнөх төрх байдал





**Зураг.№-30 техникийн нөхөн сэргээлтийн үйл явц**



**Зураг.№-31 техникийн нөхөн сэргээлтийн үйл явц**

## **5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Цагаанчулуутын амны алтны үндсэн ордын орчимд буюу уурхайн орчимд төслийн нөлөөлөлд өртөж нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал гарахгүй учир “Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө” тусгайлан боловсруулах түүнийг хэрэгжүүлэх шаардлагагүй болно.

## **6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө биелэлт**

Цагаанчулуутын уурхайн ашиглаж эхэлсэн үеэс өнөөг хүртлэх 10 гаруй жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс тэмдэглэгдээгүй бөгөөд 2017 онд Археологи, Палентлогийн хүрээлэнгүүдээр талбайн хэмжээнд судалгаа хийлгэсэн.

Эдгээр судалгаат ажлын үр дүнгээр “Түүх, соёлын өв” илрээгүй / дүгнэлт хавсаргав/ 2023 оны уул ажлын явцад түүх соёлын зүйлс илэрээгүй болно

## **7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө биелэлт**

Цагаанчулуутын уурхай нь баяжуулах, боловсруулах үйл ажиллагаандаа ямар нэг химийн бодис ашигладаггүй бөгөөд олборлолт хийхийн тулд үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх материал ашиглах ба гамшгаас хамгаалах эрсдлын үнэлгээг 2018 онд болон 2021 онд хийлгэсэн. Иймээс “Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө”-г тусгайлан боловсруулах шаардлагагүй.

## **8. Осол, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Цагаанчулуутын уурхайн алтны үндсэн ордыг далд аргаар хязгаарлагдмал орчинд ажиллаж буй талбайд анализ хийж эрсдлийг бууруулах арга хэмжээг ерөнхий инженерын удирдлага дор инженер техник, ХАБЭА-н ажилчид ажлын талбайд эрсдэлгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж зохион байгуулж ажлаа явуулсан. Уулын бүсэд ажиллаж буй ажилчидад ажилд гарахын өмнө ээлж ахлах мастер тухайн өдөр хийх ажлын наряд, ХАБЭА-н ажилтан аюулгүй ажиллагааны зааварчилгаа, эрсдлийн талаарх бодит мэдээлэлийг өгч анхааруулах тэмдэг орохыг хориглосон талбайд хил хязгаарыг зааглаж ажлын талбайд тухайн ээлжийн ахлах ажилтан хяналт тавьж эрсдэлгүй үйл ажиллагаа явуулж байна.

Гал түймэр гал гарах шалтгаан гал унтраах арга барилд ажилчдыг сургах дадлагыг 2,4-р улиралд онол, практик сургалтыг зохион байгуулав.

№	Болзошгүй аюул осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Хамрах цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян\төг	Нийт зардал мян\га	Давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Осол, эрсдлийн менежментын төлөвлөгөөний биелэлт</b>								Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, 2012 он; -“Галын аюулгүй байдлын тухай” хууль, 1995 он; -“Галын аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, 2012 он; -MNS 4244-94 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
2	Гал түймэр	ГАА даган мөрдөх ажилчид онол болон практик сургалтуудыг зохион байгуулсан	Нийт ажилтан	2	200	400	2	
3	Үер ус	Ил уурхайн хилээр шуудуу татав	Ил уурхайн карьер баруун хэсэгт	1	0	0	1	
Осол, эрсдлийн менежментын төлөвлөгөөний нийт зардал					<b>2850 мян\төг</b>			

**Уурхайд ажиллаж буй ажилчдад ХАБЭА-н сургалт орж буй ажлын үйл явц**



Зураг№-32 ХАБЭА-н сургалт





**Зураг№-33** Галын аюулгүй байдлын практик сургалт



**Зураг№-34** Галын аюулгүй байдлын практик сургалт

## 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн үйл ажиллагаа явагдаж буйтай холбогдуулан үйлдвэрлэлийн явцад гарч буй хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайн бүсэд 3 төрөлд ялган ангилав.

### а. Ахуйн хог хаягдал

- Энгийн хог хаягдал\ ажилчидын байранд цэвэрлэгээ хийх болон ахуйн хэрэглээнээс гарч буй хог хаягдлыг 6:3м харьцаатай зүфэнд цуглуулсан бөгөөд уурхайн үйл ажиллагаа зогсохын өмнө Сэлэнгэ аймгийн Баянгол сумын хогийн цэгт төвлөрүүлж хаяна.

- б. 2догч хог хаягдал \ахуйн хэрэглээнээс гарсан хуванцар сав, цаас зэргийг ялган 2:1.5м харьцаатай хашаанд цуглуулав.

### с. Ахуйн шингэн хог хаягдал:

Ажиллагсдын хоолыг үйлдвэрлэх явцад гарч буй шингэн хог хаягдлыг 3:2.5 м<sup>2</sup> харьцаатай зумфэнд цуглуулдаг. Ажиллагсад усанд орох, хувцас угаах, нүүр гар угаах үед ашиглагдсан бохир усыг 3:4 харьцаатэй зумфэнд цуглуулдаг байсан бөгөөд 2021онд 10тн багтаамжтай чайныг суурилуулан лагыг тунгаан авч саарал усыг хөрсөнд нэвчүүлэх аргыг ашиглан зайлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

### д. Аюултай хог хаягдал:

Байгальд удаан шингэдэг бөгөөд ууршилт явагдаж агаарт дэгдэн хүний эрүүл мэнд болон ургамалан бүрхүүлд сөргөөр нөлөөлөх хог хаягдалыг аюултай хог хаягдал гэнэ. Аюултай хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулж бүртгэж дахин боловсруулагдах хог хаягдлыг 2-р дахь түүхий эд боловсруулах цэгт тушаана. Машин техникийн засвар үйлчилгээг засварын талбайд хийж хөрсний бохирдол болон асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажилласан. Машин техникт үйлчилгээ хийхдээ тос, маслыг хуванцар саванд тосож авч аюултай хог хаягдлыг цэгт тушаах ажлыг техникийн операторуудад заавар өгч хэвшүүлж сургасан.

№	Хог хаягдлын ангилал	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал мян\төг	Хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Б. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт</b>								
1	Ахуйн хаягдал	Зориулалтын цэгт	Хатуу	тн	15	0	сар	-“Хог хаягдлын тухай” хууль, 2012 он; -MNS 5924:2008 “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага”; - MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага” (нүхэн жорлон, угаадасны нүх байгуулахад ашиглах материалыг сонгохдоо уг стандартыг мөрдөнө); -MNS 4943-2011 “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус.
			Бохир ус	м <sup>3</sup>	72	0	сар	
			Хаягдал яс	тн	0.5	0	Сар	
			Үнс	тн	1	0	Сар	
	Хоёрдогч хаягдал	ангилах	Цаас, картон	кг	20	0	Сар	
		ангилах	Шил сав	кг	-	0	Сар	
		ангилах	Хуванцар	кг	45	0	Сар	
		ангилах	лааз, сав	кг	-	0	Сар	
2	Үйлдвэрийн хаягдал	Зориулалтын цэгт	Хатуу хаягдал	тн	6	0	Сар	
3	Аюултай хаягдал	Зориулалтын цэгт	Ашигласан тос	л	85	0	сар	
		Зориулалтын цэгт	Шатах, тослох материалын сав	кг	-	0	Сар	
		Зориулалтын цэгт	Аккумулятор	ш	0	0	сар	
		Зориулалтын цэгт	Хуучин дугуй	ш	6	0	сар	
<b>Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт нийт</b>						600мян\төг		



Зураг№-35 Ахуйн хог хаягдалын цэг



Зураг№-36 Шингэн хог хаягдалын цэг



Зураг№-37 Аюултай хог хаягдалын цэг



**10. Орчины хяналт- шинжилгээний хөтөлбөр**

Төсөл хэрэгжиж буй талбайд ил аргаар хүдэр олборлох болон баяжуулах үйлдвэрт хүдэр боловсруулах үйл ажиллагааг явуулж байгаатай холбогдуулан хөрс, ус, агаарын шинжилгээг Сэлэнгэ аймгийн УЦУОХШГазарт 5-р сард, БОСШТ Уур амьсгаллын өөрчлөлтийн хамтын ажиллагааны төвд шинжилгээ хийлгэв.

Хүснэгт№-7

№	Үзүүлэлт	Дээжний цэгийн байршил	Давтамж тоо\ширхэг\	Нэгжийн зардал мян\төг	Нийт зардал мян\га	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
<b>Орчины хяналт- шинжилгээний хөтөлбөрийн биелэлт</b>						-MNS 0900:2010 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”	
1	Агаар	Уурхайн талбайд	1	33.5	33.5		
2	Хөрс	Уурхайн талбайд	12	-	1200		
		Ус	Унд ахуйн ус,	2	49.7		99.4
			Үйлдвэрийн гүний худаг	5	-		291.7
3	Хүнд металл бусад	Эргэлтийн ус	6		224.7		
		Цэвэр, бохир ус	4	78	312		
<b>Орчины хяналт- шинжилгээний хөтөлбөрийн биелэлт нийт зардал</b>					<b>2678.94мян\төг</b>		

## Мониторингийн цэгүүдийн солбицол

Хүснэгт №8

Цэгийн нэр	координат		Тайлбар
	X	Y	
Хөрс №1	587556.7838	5395316.9701	План зурагт бор өнгөөр дүрслэн үзүүлэв
Хөрс №2	587254.4267	5395271.6098	
Хөрс №3	587386.1088	5395197.9772	
Ус №1	587441.2193	5395148.4028	План зурагт цэнхэр өнгөөр дүрслэн үзүүлэв
Ус №2	587223.0073	5395211.6057	
Агаар №1	587449.5549	5395314.6300	План зурагт улаан өнгөөр дүрслэн үзүүлэв
Агаар №2	587237.0388	5395305.1185	

**11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт****Хүснэгт№-9**

№	Арга хэмжээ	Төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хариуцсан албан тушаалтан
<b>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт</b>						
1	Орон нутгийн малчин Галсанбалжир сүү цагаан идээ , мах авч уурхайн хэрэгцээнд нийлүүлэн ажиллав	Үхэр	5	1500	7500	Уурхайн Дарга, Нягтлан
		Хонь	12	230	2760	
		Ямаа	2	150	300	
		Сүү	150	0.14	210	
2	Стандартын шаардлага хангасан ХХ-н хувцас хэрэгслээр зун болон өвлийн нормыг эдэлгээний хугацааг 6-н сараар тогтоож ажилчдад олгов.	Зуны норм	20	180	3600	Уурхайн дарга, Нягтлан ХАБЭА-ажилтан
		Өвлийн норм	20	230	4600	
3	Эрүүл мэндийн үзлэгт хамруулав	ЭМС А\314	-	-	-	Уурхайн дарга
<b>Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал</b>				<b>18970мян\төг</b>		

**12. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин оршин суугчдад тайлагнах хуваарийн биелэлт хүснэгт.№-10**

№	БОМТХ Т-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнасан хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулсан хугацаа	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулсан газрын байршил
Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт							
1	Сэлэнгэ аймгийн ажлын хэсэгт БОМТ 2023 оны хэрэгжилтийг тайлагнав.	Бичгээр Хурал, зөвлөгөөн	Тайлангийн агуулгаар	2023.11	250		Сэлэнгэ аймагт Байгаль орчин аялал жуулчлалын яаманд 2021.11 сард тайлагнав.
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт нийт зардал					250 мян\төг		

**Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд  
гарсан нийт зардал**

Хүснэгт.№-11

№	Арга хэмжээ	Нийт
2	Сөрөг нөлөөлийг бууруулах төлөвлөгөөний биелэлт	1419
3	Нөхөн сэргээлийн төлөвлөгөөний биелэлт	0
3.1	Тэр бум мод	3447.5
4	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт	21400
5	Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний биелэлт	0
6	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт	0
7	Химийн бодис эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	0
8	Осол эрсдлийн бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	200
9	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	600
10	Орчины хяналт-шинжилгээний хөтөлбөр	2678.94
11	Удирдлага зохион байгуулалт менежментийн төлөвлөгөөний биелэлт	18970
12	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	250
<b>БОМ- төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн нийт зардал</b>		<b>48965.44мян\төг</b>

# Хавсралт

1. Аж ахуй нэгж байгууллагын гэрчилгээний хуулбар
2. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн 1817А хуулбар
3. Байгаль орчинч нарийвчилсан үнэлгээний нүүр
4. Шинжилгээний хариу